

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛЫН ӨНГӨРСӨН, ӨНӨӨ,
ИРЭЭДҮЙ: ТҮҮХИЙГ ШИНЭЭР
СӨХӨХӨД

1992 оны 3-р сард АНУ-ын Зүүн Теннесси Их сургуулийн түүхийн профессор Генри Анткевич тус хүрээлэнгийн урилгаар Монголд 10 хоног зочилж, манай нэрт түүхчидтэй санал солилцсон билээ. Тэрээр АНУ-ын их дээд сургуулийн оюутнуудад зориулсан түүхийн сурах бичигт Монголын түүхийн холбогдолтой бүлэг зүйлийг бичиж байгаа ажээ. Г.Анткевич Монголоос буцаж очоод түр багшилж байгаа Японы Ибараки их сургуулийн жилийн чуулганд Монголын тухай илтгэл тавьсны (1992. 06. 03) хураангуйг бидэнд ирүүлснийг уншигч та бүхэндээ толилуулж байна.

Сэтгүүлийн редакц

1990 оноос хойш Монголын удирдлага дэлхийн тавцанд, ялангуяа хуучин ЗХУ-д гарсан өөрчлөлттэй уялдуулан улс төрийн бодлогоо шинэчлэн тохируулжээ. Үүнээс өмнө ч гэсэн Монголын коммунист удирдагчид өөрсдийн гол түшиг тулгуур Москвагаар ах дүүгийн харилцаандаа зохицуулалт хийж эхэлсэн байна.

Монголын эдгээр удирдагчид 1921 оны хувьсгалаас улбаатай 70 жилийн уламжлалыг агуулагчид болно. Тэд 1990 онд «Ардчилал»-д шилжих шилжилтийг зовлонгүй давсан, мөн энэ 1992 оны 6-р сард болох сонгуулийг ч нэгэн адил давах тун бололцоотой.

Улс төрийн хуучин уламжлалыг баримтлагч энэ удирдагчид олон намын өрсөлдсөнд ялж чадах эсэх нь түүхийг хэрхэн үзэж, «ашиглаж» байгаагаас багагүй хамаарна. Олон жил засгийн эрхэнд байсан уламжлалтай төдийгүй өнөө ч албан тушаалдаа хэвээр улс төрчид түүхийг хэрхэн «ашиглаж» байна гэдэг нь үндэсний шилжилтийн үеийн асуудлыг судлахад нэн ач холбогдолтой.

Өнөөгийн улс төрчид өнгөрсөн түүхээс чухам юуг нь сонгон авч, өнөө болон ирээдүйд байр сууриа бэхжүүлэхэд ашиглаж байгаа нь түүхчийн хувьд нэн сонирхолтой, Монголын байдал сэргэн мандал болон гандан буурахын тухай мөнхийн маргааныг илтгэн харуулж байна. Энэхүү маргаан «түүхийн төгсгөл» болон «түүхийн дахин сэргэлтийн» тухай Өнөөдрийн олон орны эрдэмтдийн нийтлэг хэлэлцүүлэгт тусгалаа олж байна. Монголын байдлыг задлан шинжлэхэд ч энэ хэлэлцүүлэг дөхөм болох учиртай.

Б. Монголчууд өнөөдөр түүхээ сонирхож байгаа нь их төлөв Чингис хааны үүрэг ролийг дахин үнэлэхтэй холбогдоно. Түүний дүр 70-аад жил Монголын улс төрийн тавцанд байраа эзэлж нэг л чадахгүй байсан бол өнөөдөр тэрээр үндэсний баатар болж хувирчээ. Чингис хаан монголчуудын үндэсний ухамсрыг сэргээх шинэ төв гэж хэлж болно. Цэргийнхэн хүртэл Чингис хааныг өргөмжлөх болсныг хэлэх нь зүйтэй. Чингис хааны мэндэлсний 830 жилийн ойд зориулж Үндэсний БХЯ наас зохиосон эрдэм шинжилгээний бага хуралд оролцох завшаан олдсон юм. Офицеруудын ордонд болсон энэ хурлын индэрт гарсан илтгэгч болгон Чингис хаан улс үндэстэндээ юу зааж сургасныг офицерын бүрэлдэхүүнд таниулж байлаа.

Улс төрийн уур амьсгал яаж ч эргэлээ гэсэн Чингис хааны өв уламжлалыг ихэд чухалчлан үзэх нь дамжиггүй.

Эцэст нь хэлэхэд, Монголд болж байгаа үйл явдалд Япон үүрэгтэй бөгөөд Япон улс идэвхтэй байр суурь баримтлахыг би дэмжиж байна.

**ШИНЖЛЭХ УХААНЫ ГАВЬЯАТ
ЗҮТГЭЛТЭН, ТӨРИЙН ШАГНАЛТ
АКАДЕМИЧ Б. ШИРЭНДЭВИЙН
80 НАСНЫ ОЙД**

Базарын Ширэндэв 1912 онд Сайнноён хан аймгийн Далайчойнхор вангийн хошууны их баг, одоогийн Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр суманд төрсөн. Тэрбээр багадаа өөрийн эцэг Базар бичээчээр монгол бичиг заалгаж байв. 1924—29 онд Нүхтийн хүрээнд шавилан сууж байгаад бага сургууль, цэцэрлэг хотын дунд сургууль, Улаанбаатарт намын сургуульд тус тус суралцаж байв. 1931 оноос ЗХУ-ын Улан Үдийн Рабфак хэмээх бүрэн дунд сургуульд 6 жил, Эрхүүгийн Их сургуульд 5 жил суралцаж төгссөн.

1952 онд Москвад дэд эрдмийн зэрэг хамгаалжээ. 1957—60 онд ЗХУ-ын УА-ийн ДДСХ-ийн докторантурт суралцаж докторын цол (XIX-XX зууны зааг дээрх Монгол орон сэдвээр) хамгаалсан.

Б. Ширэндэв улс төр, олон нийтийн ажилд олон жил идэвх зүтгэлтэй ажилласан. Тэрбээр Багшийн дунд сургуульд багшилж, 1941—43 онд засгийн газарт референт, ТХ-ны лекторын товчоог удирдаж байв. 1943—47 онд ТХ-нд ухуулга эрхэлсэн нарийн бичгийн дарга, 1943—53 онд УИС-ийн захирал, Гэгээрлийн яамны сайд, 1954-57 онд СнЗ-ийн орлогч даргаар ажиллаж байв. 1960—81 онд БНМАУ-ын ШУА-ийн анхны ерөнхийлөгчөөр ажиллаж, Монголын Шинжлэх ухааны Академийг үндэслэн байгуулж бүх талаар бэхжүүлэхэд үлэмж их хувь нэмэр оруулсан юм. Б. Ширэндэв 1949-59 онд энх тайвны хорооны дарга, Монгол-Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэгийн дарга, Ази-Африкийн эв санааны нэгдлийн хорооны даргаар сонгогдон ажиллаж байв.

Б. Ширэндэвийн бүтээлүүд Монголын түүхийн шинжлэх ухаанд жинтэй байр суурь эзэлдэг. Түүний гол бүтээл нь «XIX—XX зууны зааг дээрх Монгол орон» (25 х.х), УБ, 63, «МАХ-ын түүх» (үүгээрээ төрийн шагнал авсан) (25 х.х), «Бүтээлүүдийн эмхтгэл» тус тус Монгол, орос хэлээр хэвлэгджээ. Мөн «Хичээнгүй сайд Цэрэндорж» УБ, 65, «ШУА-ийн товч түүх» УБ, 81, «Хатанбаатар Магсаржав», «Сэрэл» зэрэг ном зохиож 200-гаад өгүүлэл, бусад олон товхимол бичиж хэвлүүлжээ. Олон бүтээл нь орос, англи, хятад, герман, араб хэлээр орчуулагдсан юм. Б. Ширэндэв «Монголын түүх» нэгэн боть, гурван боть зохиолын зохиогч редактораар ажилласан.

Б. Ширэндэв УИС-ийн профессор, 1943 оноос ШУ-ны хүрээлэнгийн гишүүн, 1961 оноос ШУА-ийн гишүүн, доктор, ЗХУ, Болгар, Унгар, Ардчилсан Герман, Чехословак, Польш улсын ШУА-ийн гадаад гишүүн, Английн «Лидс» Их сургуулийн хүндэт доктор юм.

Түүний хөдөлмөрийг өндрөөр үнэлж төр, засгаас Сүхбаатарын одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон 4, Алтангадас одонгоор шагнажээ. Б.Ширэндэвийн шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийг гадаадад ч өндрөөр үнэлдэг. Тэрбээр Польшийн төрийн гавьяаны одон, Солонгосын төрийн хүндэт одонгоор шагнагдсан юм.

1991 онд Б.Ширэндэвийг манай шинжлэх ухааны анхны гавьяат зүтгэлтэн цолоор шагнасан билээ.

Б.Ширэндэв гуайн 80 насны ойд зориулж гадаадын олон байгууллагаас баярын бичиг ирүүлсний дотор Оросын ШУА-ийн Ерөнхийлөг чийн ирүүлсэн баярын бичигт түүний шинжлэх ухаанд оруулсан гавьяаг үнэлэхдээ “Та найрамдалт Монгол улсад өндөр албан тушаал хашиж, Монголын ШУА-ийг үндэслэгчийн нэг болоод дараа нь олон жил анхны ерөнхийлөгчөөр нь ажиллахдаа манай орон, Монголын эрдэмтдийн хамтын ажиллагаанд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан билээ.

Таны олон талын ажиллагаа олон улсад өндрөөр үнэлэгдсэн юм. Бид таныг Оросын ШУА-ийн гадаад гишүүнээр сонгогдсонд бахархаж байна»

Оросын ШУА-ийн Ерөнхийлөгч Ю. С. Осипов

Оросын ШУА-ийн дэд ерөнхийлөгч В. Н. Кудрявцев

Эрдэмтэн нарийн бичгийн дарга И. М. Макаров гэжээ.

Монголын Шинжлэх ухааны Академийг үндэслэгчийн нэг, төр, олон нийтийн зүтгэлтэн, академич Б.Ширэндэв гуай өдгөө Монголын шинжлэх ухаанд сэтгэл зүрхээ зориулж бүтээлчээр хөдөлмөрлөсөөр явна.

С. Батсайхан

ЭКСПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОВСРУУЛАХ БҮС

Нэг хүнд ногдох үндэсний орлогын хэмжээ, аж үйлдвэржилтийн хөгжлийн төвшний хооронд нягт уялдаа холбоо байдаг билээ. Дэ хийн банкнаас гаргадаг «Дэлхийн хөгжлийн талаарх мэдээлэл-д 120 орны хөгжлийн төвшинг нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүний хэмжээгээр тодорхойлж, дараах бүлэгт хуваасан байна. Үүнд:

| | |
|-------------------------------|--|
| Эдийн засгийн хөгжлийн төвшин | Нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүн |
| Бага орлого | 273 ам. долл. |
| Дунд орлогын доод хэмжээ | 1188 ам. долл. |
| Дунд орлогын дээд хэмжээ | 2492 ам. долл. |
| Их орлого | 15921 ам. долл. |

Аж үйлдвэржилтийн зүй тогтол

Өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн хөгжлийн туршлагаас үзэхэд тэдгээр нь аж үйлдвэржилтийн бодлогыг тодорхой зүй тогтлоор хэрэгжүүлж ирсэн байна.

1. Аж үйлдвэржилтийн бодлогыг хэрэгжүүлэхээс өмнө өөрийн хүчинд тулгуурлах бодлого явуулах;

2. Дэлхийн зах зээлд нээлттэй эдийн засгийн бодлого» явуулж, түүхий эд материалыг гадагш гарган, бэлэн боловсруулсан бүтээгдэхүүнийг гаднаас оруулах;

3. «Аж үйлдвэржилтийн эхний шат»: дотоодод материал, түүхий эдээ боловсруулан импорт оруулах салбарыг хөгжүүлэх;

4. «Аж үйлдвэржилтийн хөгжингүй шат»: аж үйлдвэрийн бүтцийг боловсронгуй болгож, аж үйлдвэрийн технологийг шинэчилж, дотооддоо боловсруулан бэлэн бүтээгдэхүүний экспортын хэмжээг өсгөх;

5. «Хэт аж үйлдвэржсэн нийгэм»: аж үйлдвэрийн бүтцэд үйлчилгээний салбар зонхилно. Үйлдвэрлэгчид гадаадад хөрөнгө оруулахыг голлоно. Дотоодод боловсруулсан бэлэн бүтээгдэхүүний импорт үлэмж өснө.

Экспортын бүтээгдэхүүн боловсруулах бүсийн байр суурь

Өндөр хөгжилтэй орнуудын ихэнх нь аж үйлдвэржилтийн эхний шатанд Чөлөөт худалдааны бүс (Jree Trade Zones) буюу Экспортын бүтээгдэхүүн боловсруулах бүс (Export processing Zone) -ийг байгуулж,

гадаадын хөрөнгө, технологийг татан оруулах бодлого баримталж ирсэн байна.

Экспортын бүтээгдэхүүн боловсруулах бүсийн зорилго нь:

— ажлын байр нэмэгдүүлэн, илүүдэл ажиллах хүчийг ажлаар хангах, ажилгүйдлийг багасгах;

— гадаад валютын нөөцийг өсгөн, тооцооны балансыг сайжруулах;

— гадаадын техник, технологи, удирдлагын арга барилыг өргөнөөр нэвтрүүлэх;

— гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулан татах;

— түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрүүдэд боловсруулдаг болгох.

Одоо дэлхийд экспортын бүтээгдэхүүн боловсруулах бүс 80 орчим байгаагаас гуравны нэг нь Ази, Номхон далайн бүс нутагт байна. Үүнд: Гонконг, Сингапур дахь чөлөөт боомт, Мексик дэх хил орчмын чөлөөт бүс, Турк, АНУ дахь чөлөөт худалдааны бүс зэргийг нэрлэж болох юм.

Хөрөнгө оруулагчдад үзүүлэх хөнгөлөлт

Экспортын бүтээгдэхүүн боловсруулах бүсэд хөрөнгө оруулагчид нь үйлдвэрлэлийн орлогын татвар, импортын татвар, импортын квот, хөрөнгийн ялгааны татвар, акцизын татвараас чөлөөлөгдөнө. Эдгээр татвараас чөлөөлөх хугацаа нь орон бүрд адилгүй бөгөөд ихэнхдээ 5 жил, зарим тохиолдолд 3, 8, 10 жил байдаг байна.

Үүнээс гадна санхүүгийн талаар тус бүсэд олсон ашиг, орлогоо эх орондоо буцааж оруулах боломжийг баталгаажуулах; гадаадын хөрөнгө оролцсон үйлдвэрийн газрыг тухайн орны улсын өмч болгохоос хамгаалах, гадаад валютын солилцоог чөлөөтэй болгох зэрэг тодорхой хөнгөлөлт үзүүлдэг.

Хөрөнгө оруулагчид нь ус, цахилгаан эрчим хүч хэрэглэх, үйлдвэрээ барих газар түрээслэхэд хөнгөлөлттэй тарифаар хангадаг.

Ихэнх тохиолдолд татвараас чөлөөлөх хугацааг тус бүсэд оруулсан хөрөнгийн хэмжээ, дэвшилт технологи нэвтрүүлсэн байдал, ажлын байрын өсөлт, экспортын хэмжээнээс хамаарч сунгана.

Экспортын бүтээгдэхүүн боловсруулах бүс нь тухайн орны нутаг дэвсгэр дээр үйлчилж байх хугацаанд түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг импортлох, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж оруулахад гаалийн татвараас чөлөө лөгдөнө.

Экспортын бүтээгдэхүүн боловсруулах бүсийн дотоодын арилжаа

Экспортын бүтээгдэхүүн боловсруулах бүсүүдийн ихэнх нь төрөл бүрийн давуу тал, хөнгөлөлттэй байдаг учир дотоодын зах зээл дээр дотоодын үйлдвэрүүдтэй өрсөлдөж болохгүй нь мэдээж юм. Гэвч дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь тус бүсэд боловсруулсан бүтээгдэхүүнтэй өрсөлдөх чадваргүй байх тохиолдолд, дотоодын арилжааг хязгаарлахгүй.

Хятад, Энэтхэг, Нигер зэрэг том зах зээлтэй орнууд нь үйлдвэрлэгчид, хөрөнгө оруулагчдын анхаарлыг татдаг нь зүйн хэрэг. Иймээс үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ тодорхой хэсгийг эдгээр оронд борлуулах зөвшөөрлийг үйлдвэрлэгчдэд олгох нь тэдгээрийг татах чухал арга хэмжээ болох нь дамжиггүй юм. Эдгээр хөрөнгө оруулагчдыг экспортын бүтээгдэхүүн боловсруулах бүсэд урамшуулан оролцуулснаар дотоодын үйлдвэрийн газруудын хөдөлмөрийн бүтээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

Дэд бүтэц, үйлчилгээний хангамж

Экспортын бүтээгдэхүүн боловсруулах бүс нь зам тээвэр, боомт, онгоцны буудал, ус, цахилгаан эрчим хүч, харилцаа холбооны систем зэрэг дэд бүтцийн үйлчилгээгээр хангагдана.

Мөн эмнэлгийн тусламж, банк, даатгал зэрэг нийгмийн үйлчилгээний салбар ч тус бүсэд хөгжиж байна.

Хөдөлмөрийн хууль

Экспортын бүтээгдэхүүн боловсруулах бүсэд хөрөнгө оруулахад гол давуу тал нь тухайн орны хямд ажиллах хүч юм. Зарим бүсэд ажилчдын эрхийг хязгаарласнаар ажиллах хүчний хангамж тогтвортой байх болно гэдэг бодлого явуулдаг байна. Жишээ нь, Малайзын экспортын бүтээгдэхүүн боловсруулах бүсэд цахим бүтээгдэхүүний үйлдвэрийн ажилчид нь үйлдвэрчний байгууллагад нэгдэх эрхгүй байсан бөгөөд 1983 онд Засгийн газраас уг бодлогыг өөрчилсөн байна.

Хөрөнгө оруулалт явагддаг салбарууд

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 80—90 хувийг экспортод гаргадаг салбарыг эдгээр бүсэд урамшуулан хөгжүүлдэг.

Зарим тохиолдолд дотоодын хөрөнгө оруулагчдыг оролцохыг зөвшөөрдөггүй бөгөөд хамтарсан үйлдвэр байгуулахыг хязгаарладаг.

Ихэнх бүсэд хөдөлмөрийн багтаамж ихтэй хөнгөн үйлдвэрийн салбар, цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлд хөрөнгө оруулдаг байна. Гэтэл Тайванд 60-аад онд хөдөлмөрийн багтаамж ихтэй хөнгөн үйлдвэрийн салбарыг урамшуулан хөгжүүлж байсан бол 70-аад онд өндөр технологи бүхий салбарыг хөгжүүлж, 80-аад онд шинжлэх ухаан, техник, технологид хөрөнгө оруулахыг дэмжих бодлого явуулж ирсэн байна.